

БАТЛАВ

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Б.БУЯННЭМЭХ

.....

БАТЛАВ

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН
“ЯАРМАГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.НЯМЦЭРЭН

.....



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ
ЯАРМАГ ХХК-НИЙ АРЬС ШИР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙНН РЕГИСТРИЙН ДУГААР – 2595117/

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ,
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

...../ /

БОЛОВСРУУЛСАН:

ЯАРМАГ ХХК-ИЙН МЕНЕЖЕР

...../ Б.ДОЛГОР /

Улаанбаатар хот
2024 он

1. Төслийн товч танилцуулга

Төслийн байршил: Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 20-р хорооны нутаг дэвсгэрт хуучнаар АШҮН-ийн хашаанд

Төсөл хэрэгжүүлэгч: Яармаг ХХК, регистрийн дугаар 2595217, улсын бүртгэлийн дугаар 9011470088

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, АШҮН-н хашаанд, Үйлдвэр -17042/44. Утас: 99134550, 99040007

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааны товч түүх, барилга байгууламж, хүчин чадал:

“ЯАРМАГ” ХХК нь 1992 онд Монгол орны малын гаралтай түүхий болох арьс, шир бэлтгэх, боловсруулах, экспортонд гаргах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зорилгоор байгуулагдсан бөгөөд өнөөдрийг хүртэл бизнесийн үйл ажиллагаагаа өргөтгөн, 28 жил тогтвортой эрхэлж байгаа зах зээлийн нийгмийн анхны үйлдвэрүүдийн нэг билээ.


“ЯАРМАГ” ХХК нь анх 1992 онд Яармаг Хоршоо хэлбэрээр БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Х.Бямбажав өөрийн санаачлага, хөрөнгөөр үүсгэн байгуулагдаж тарвага ангийн арьс боловсруулан ОХУ-д экспортлон үйл ажиллагаагаа эхэлсэн юм.

1993-2000 онд жилд 2-50 мянган ширхэг тарвага, каракуль, булганы арьс боловсруулж 50-1200 үслэг эдлэл хувцас, 1997 оноос бодын арьс боловсруулж гутлын булигаар үйлдвэрлэж, улмаар үйлдвэрлэлээ өргөтгөн арьс шир боловсруулах тоног төхөөрөмжөө шинэчлэн хүчин чадлыг нэмэгдүүлснээр 2000 оноос “Яармаг” хоршоог “Яармаг” ХХК болгон өөрчлөн байгуулсан. Үйлдвэрлэлийн барилгыг өргөтгөн барьж, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр жилд боловсруулах арьс ширний тоо хэмжээ нэмэгдэж хоногт 4500 богын арьс, 1000 бодын арьс боловсруулах хүчин чадалтай болсноор жилийн орлого, ажлын байрны тоо нэмэгдсэн. 2014 оноос гадаад зах зээлээ тэлж хагас боловсруулсан хонь, ямаа, үхрийн арьсыг Европын зах зээлд Итали, Испани, АНЭУ, Турк болон Хятад улс руу экспортолж байна. Хан-Уул дүүргийн 20-р хороонд байрлах АШҮН-ийн хашаанд өөрийн эзэмшлийн газарт үйлдвэрийн болон оффисын байр, Монгол шир ХХК-ны үйлдвэрийн байрыг түрээсийн гэрээний дагуу ашигладаг.


Үйлдвэрлэлийн барилга байгууламж, талбай хэмжээ:

– Үйлдвэрийн барилга 1 – Арьс шир боловсруулах үйлдвэр 1829 м2 -механик цех

- Үйлдвэрийн барилга 2 – Арьс шир боловсруулах үйлдвэр 6610 м2 Монгол шир ХХК-тай ажлын байр түрээслэх гэрээгээр ашиглаж буй үйлдвэрийн байр. – нойтон цех
- Үйлдвэрийн барилга 3 – Бэлэн бүтээгдэхүүний агуулах 256 м2



Зураг 1 Монгол шир ХХК-ийн байр – Нойтон цех



Зураг 2 Яармаг ХХК-ийн байр – Механик цех

Үйлдвэрлэлийн хүчин чадал

- Хоногт 4000-4500 богийн арьс
- 800-1000 бодийн шир
- 100 мян.дм² эцсийн бүтээгдэхүүн краст боловсруулах хүчин чадалтай.

Үйлдвэр өдрийн 8 цагаар, технологийн шаардлагаар зарим дамжлага илүү цагаар ажилладаг ба нэг ээлжтэй. Үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд БНХАУ, Чех, Итали улсад үйлдвэрлэгдсэн.

Төсөл хэрэгжүүлэгчийн тусгай зөвшөөрөл, бусад бичиг баримтууд

ХХАБодис импортлох, ашиглах тусгай зөвшөөрөл – №0002103, 2022/03/01 3жил

Ус ашиглуулах дүгнэлт - №15, 2023/04/04

Ус ашиглах эрхийн бичиг - №24/2015, Сунгалт – 2022/05/30: 3 жил

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбай ХУД-ын 20-р хороо Арьс ширний үйлдвэрийн нэгдлийн хашаанд байрлалтай.

Физик газарзүй: Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг нь Дархан цаазат Богдхан уулын баруун хойд талд Туул голын хөндийд байрлана. Туул голын хөндий нь зүүнээс баруун тийш 30 орчим км сунасан, өргөн нь 4-5 км, далайн түвшинээс дээш 1250-1300м өргөгдсөн бөгөөд урд талаараа Баянзүрх уул (1843.3м), хойд талаараа Чингэлтэй түүний салбар уулсаар хүрээлэгдэнэ.

Уур амьсгал: Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай. Өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -49°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 38.6°C байдаг. Жилийн дундаж температур нь -3°C, хамгийн хүйтэн 1-р сарын температур нь -26°C байх бөгөөд -30°C-аас бууж хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна. Жилдээ салхигүй өдөр 100 орчим байх бөгөөд салхины хурд 4-6 м/с, баруун хойд зүгийн салхи голлоно. Улаанбаатарт жилд дунджаар 233 мм тунадас унаж, ууршилт нь 648 мм болдог. Чийгшлийн байдал 0.36 байдаг.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих талбай нь бүрэн хатуу хучилттай юм. Тиймээс төслийн талбайн хөрсөн бүрхэвч нь үржил шимгүй болж, байгалийн унаган төрхөө хэдийн алдсан байдалтай байна.

Амьтны аймаг: Амьтан, ургамлын аймгийн экосистемийн шинж төрх бүрэн алдагдаж, амьтны зүйлийн бүрдэл нь хот суурин, хүний ойр орчимд амьдардаг синантроп зүйлүүд суурьших болжээ. Улаанбаатар хотод амьтны аймгаас хамгийн өргөн тархсан цөөн зүйлийн шувуу, шавж, хөхтөн судалгаагаар тодорхойлогдсон байдаг. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн ба хээрийн бор шувуу, шаазгай, сохор элээ, хөх бор тагтаа, хар элээ, хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, гэрийн хулгана, үлийн цагаан оготнууд байна.

Хүснэгт 2.1 Төслийн талбайн координат

| Д/д | Х | Ү | Талбайн хэмжээ |
|-----|-----------|------------|-----------------------|
| 1. | 641708.17 | 5306334.10 | 1829.0 м ² |
| 2. | 641672.80 | 5306335.06 | |
| 3. | 641672.79 | 5306336.86 | |
| 4. | 641666.37 | 5306337.04 | |
| 5. | 641666.39 | 5306338.26 | |
| 6. | 641660.13 | 5306338.37 | |
| 7. | 641660.17 | 5306340.00 | |
| 8. | 641655.07 | 5306340.20 | |
| 9. | 641656.19 | 5306375.53 | |
| 10. | 641683.40 | 5306374.67 | |
| 11. | 641683.11 | 5306365.50 | |
| 12. | 641691.81 | 5306365.23 | |
| 13. | 641700.89 | 5306365.04 | |
| 14. | 641708.86 | 5306364.83 | |



Ярмарг ХХК-ийн нойтон цехийн үйл ажиллагаа Монгол шир ХХК-ийн үйлдвэрийн байранд явагддаг болно.

Хүснэгт 2. Монгол шир ХХК ийн талбайн координат

| Д/д | Х | Ү | Талбайн хэмжээ |
|-----|-------------|------------|----------------|
| 1. | 5308405.337 | 641632.366 | 8026 м кв |
| 2. | 5308424.668 | 641632.750 | |
| 3. | 5308438.336 | 641633.102 | |
| 4. | 5308454.811 | 641633.513 | |
| 5. | 5308454.913 | 641629.885 | |
| 6. | 5308457.244 | 641629.942 | |
| 7. | 5308457.312 | 641627.583 | |
| 8. | 5308457.379 | 641625.223 | |
| 9. | 5308458.515 | 641625.255 | |
| 10. | 5308462.513 | 641625.366 | |
| 11. | 5308462.523 | 641624.575 | |
| 12. | 5308480.489 | 641625.037 | |
| 13. | 5308480.262 | 641634.157 | |
| 14. | 5308512.330 | 641634.969 | |
| 15. | 5308511.654 | 641660.012 | |
| 16. | 5308515.876 | 641660.211 | |
| 17. | 5308515.758 | 641664.641 | |
| 18. | 5308511.535 | 641664.446 | |
| 19. | 5308510.887 | 641688.478 | |
| 20. | 5308510.648 | 641697.385 | |
| 21. | 5308510.293 | 641713.238 | |
| 22. | 5308498.932 | 641712.877 | |

| | | |
|-----|-------------|------------|
| 23. | 5308492.855 | 641712.684 |
| 24. | 5308463.547 | 641711.752 |
| 25. | 5308462.089 | 641707.656 |
| 26. | 5308445.411 | 641706.523 |
| 27. | 5308442.928 | 641706.345 |
| 28. | 5308412.469 | 641705.533 |
| 29. | 5308408.918 | 641685.487 |
| 30. | 5308405.905 | 641674.025 |
| 31. | 5308406.602 | 641649.355 |
| 32. | 5308412.665 | 641649.591 |
| 33. | 5308412.871 | 641642.150 |
| 34. | 5308405.074 | 641642.038 |



3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн хүрээнд байгалийн нөөцийг ашиглах үйл ажиллагаа явуулдаггүй. Төслийн байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг БОНҮТ-нд арьс шир боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаар орчин, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагавар нь дунд үнэлгээгээр ба экологийн бусад хэсгүүдэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй гэж дүгнэгдсэн. Химийн урвалын ба ууршилтын үр дүнд ялгарах хий, уур зэрэг нь үйлдвэрийн дотоод агаарын бохирдолтыг нэмэгдүүлэх, бохирдол гадагш алдагдах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс хаягдал ус хөрсөн бүрхэвчид нэвчих зэрэг болзошгүй сөрөг нөлөөллүүд гарч болно гэж дүгнэсэн.

Хүснэгт -3.1 Нөлөөллийн үнэлгээний нэгдсэн дүгнэлт

| Байгаль орчин | Нөлөөллийн эрчим, цар хүрээ | | | | | Нөлөөллийн Зэрэг | Хувиар |
|---|--|--------|------|-------|-------------|------------------|--------|
| | Маш бага буюу нөлөөгүй | Бага | Дунд | Их | Онц аюултай | | |
| Газрын гадарга, хэвлий | | | | | | Нөлөөгүй | |
| Хөрсөнд нөлөөлөх байдал | 1 | 2 | | | | Бага | 18.75 |
| Агаарын чанарт нөлөөлөх байдал | | | 2 | 1 | | Дунд | 18.75 |
| Гадаргын болон газрын доорх ус | | 1 | 3 | | | Дунд | 25 |
| Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал | 1 | 2 | | | | Бага | 18.75 |
| Амьтны аймаг | | | | | | Нөлөөлөлгүй | |
| Түүх соёлын өв | | | | | | Нөлөөлөлгүй | |
| Ажиллагсадын эрүүл мэндэд нөлөөлөх байдал | | | 3 | | | Дунд | 18.75 |
| Нийт | 2 | 5 | 8 | 1 | | | |
| Хувиар | 12,5% | 31,25% | 50% | 6,25% | | | |
| Дүгнэлт | Нийт үнэлгээний 12,5% нь маш бага буюу нөлөөгүй, 31,25 % нь бага нөлөөтэй, 50% нь дунд нөлөөлөлтэй 6,25% нь их нөлөөлөлтэй гэсэн ангилалд хамрагдаж байгааг үндэслэн уг төслөөс байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг “ДУНД” гэж үзэхээр байна. | | | | | | |

Тухайн төсөл хэрэгжих газар нь Улаанбаатар хот Хан уул дүүрэг 20-р хороонд оршдог бөгөөд өвлийн улиралд инверс задрахгүй үлддэг учир газар орчмын агаарын солилцоо муудаж, янз бүрийн хорт бодисоор бохирдсон агаар конвекцээр хөөрч өөр тийш зөөгдөлгүй байрандаа хурган тогтоход хүргэдэг.

3.1 Төслөөс агаарын чанарт нөлөөлөх байдал түүний үнэлгээ

Төслийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад ажиллагсад агаарын бохирдлын нөлөөлөлд өртөж болзошгүй.

| № | Нөлөөлөл | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ | | | | |
|---|--|--------------------------------|------|-------|------|-------------|
| | | Маш бага буюу нөлөөгүй | Бага | Дунд | Их | Онц аюултай |
| 1 | Арьс шир хүлээнавах, хадгалах, боловсруулах, химийн бодисыг ил задгай хадгалах зэргээс сөрөг нөлөөл үзүүлэх | | | х | | |
| 2 | Арьс шир боловсруулах үйлдвэрлэлээс ялгарах бохир ус, үйлдвэрлэлийн хаягдал, арьс ширний үлдэгдлээс орчинд бохирдол үүсэх | | | | х | |
| 3 | Арьс шир хадгалах, цэвэрлэх, угаах, шохойдох, идээлэх зэрэгт чийг ихсэх, үнэр гарч ажилчдын биед амьсгалаар дамжин мэргэжлийн өвчин эмгэг үүсэж болох. | | | х | | |
| | Хувиар | | | 66,6% | 33,3 | |

| | |
|---------|---|
| Дүгнэлт | Дээр дурьдсан нийт нөлөөллийн 66,6 хувь нь дунд, 33,3 хувь нь их нөлөөлөл үзүүлэхээр байгааг харгалзан уг төслөөс төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчмын агаарын чанарт дунд нөлөөлөлтэй байна гэж үзлээ. |
|---------|---|

3.2 Төслөөс газрын гадаргад нөлөөлөх байдал, үнэлгээ

Хан-Уул дүүргийн 20-р хорооны нутагт хэрэгжих “Яармаг” ХХК-ийн “Арьс шир боловсруулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга болон хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй болно.

3.3 Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдал, үнэлгээ:

| № | Нөлөөлөл | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ | | | | |
|----------|---|--------------------------------|-------|------|----|-------------|
| | | Маш бага буюу нөлөөгүй | Бага | Дунд | Их | Онц аюултай |
| 1 | Арьс шир хүлээн авах, хадгалах, боловсруулах, химийн бодисыг ил задгай хадгалах зэргээс хөрсөн бүрхэвч бохирдох | | х | | | |
| 2 | Тухайн үйлдвэрийн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн улмаас хөрс элэгдэж, эвдрэлд орох | х | | | | |
| 3 | Химийн ба шатах тослох материалын болон ахуйн хог хаягдалаас болж үүсэх бохирдол | | х | | | |
| Хувиар | | 33,3% | 66,6% | | | |
| Дүгнэлт: | Тухайн төсөл хэрэгжих орчмын хөрсөнд төслөөс нөлөөлөх нөлөөллийг тогтооход нийт сөрөг нөлөөллийн 33,3% нь маш бага буюу нөлөөгүй 66,6% нь бага нөлөөтэй гэсэн ангилалд тус тус хамрагдаж байна. Тиймээс хөрсөн нөлөөлөх байдлыг бага гэж дүгнэв. | | | | | |

3.4 Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал, үнэлгээ.

| № | Нөлөөлөл | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ | | | | |
|----------|---|--------------------------------|-------|------|----|-------------|
| | | Маш бага буюу нөлөөгүй | Бага | Дунд | Их | Онц аюултай |
| 1 | Арьс шир хүлээн авах, хадгалах, боловсруулах, химийн бодисыг ил задгай хадгалах зэргээс ургамлан бүрхэвч бохирдох | | х | | | |
| 2 | Тухайн үйлдвэрийн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн улмаас ургамлан нөмрөг элэгдэж, эвдрэлд орох | х | | | | |
| 3 | Хүний хөл хөдөлгөөнөө ургамлан нөмрөг элэгдэж эвдрэлд орон хөл газрын ургамлаар солигдох | | х | | | |
| Хувиар | | 33,3% | 66,6% | | | |
| Дүгнэлт: | Тухайн төсөл хэрэгжих орчимд ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөллийг тогтооход нийт сөрөг нөлөөллийн 33,3% нь маш бага буюу нөлөөгүй, 66,6 % нь бага нөлөөтэй гэсэн ангилалд тус тус хамрагдаж байна. Тиймээс ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөллийг бага гэж дүгнэв. | | | | | |

3.5 Амьтны аймагт нөлөөлөх байдал, түүний үнэлгээ:

Тус Хан-Уул дүүргийн 20-р хорооны нутагт хэрэгжих “Яармаг” ХХК-ийн “Арьс шир боловсруулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй болно.

3.6 Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдал, түүний үнэлгээ

| № | Нөлөөлөл | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ | | | | |
|---------|--|--------------------------------|------|------|----|-------------|
| | | Маш бага буюу нөлөөгүй | Бага | Дунд | Их | Онц аюултай |
| 1 | Арьс шир боловсруулах үйлдвэр нь Туул голын сав газарт байрлах тул дутуу цэвэрлэсэн болон цэвэрлээгүй бохир ус нь Туул голын усыг бохирдуулах | | | х | | |
| 2 | Дутуу цэвэрлэсэн болон цэвэрлээгүй бохир ус нь байгалийн усны эх булгууд, ялангуяа гадаргын усанд нийлснээс усны нөөцийг бохирдуулах | | | х | | |
| 3 | Цэвэрлэх байгууламжийн хэвийн ажиллагаа алдагдсан буюу түүний тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл үүсэх технологийн горим зөрчигдөх | | | х | | |
| 4 | Хуурай хог хаягдлыг ил задгай хаях, байгаль орчны болон ариун цэврийн байгууллагаас тогтоосон цэгт тусгай графикийн дагуу зайлуулахгүй байх | | х | | | |
| Нийт | | 0 | 1 | 3 | 0 | 0 |
| Хувиар | | 0 | 25% | 75% | 0 | 0 |
| Дүгнэлт | Тухайн төсөл хэрэгжих орчмын гадаргын болон газрын доорх усанд төслөөс нөлөөлөх нөлөөллийг тогтооход нийт сөрөг нөлөөллийн 25 % нь бага нөлөөтэй, 75 % нь дунд нөлөөтэй гэсэн ангилалд тус тус хамрагдаж байна. Тиймээс гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдлыг дунд гэж дүгнэв. | | | | | |

3.7 Төслөөс ажиллагсадын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:

| № | Нөлөөллүүд | Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ | | | | |
|--------|---|--------------------------------|------|------|----|-------------|
| | | Маш бага буюу нөлөөгүй | Бага | Дунд | Их | Онц Аюултай |
| 1 | Арьс ширний үйлдвэрийн хаягдал бохир ус нь нар салхины нөлөөгөөр ууршин агаарт тархсанаас элдэв өвчний нян тараах | | | х | | |
| 2 | Хаягдал ус нь хөрс, агаар ба гадаргын болон гүний усанд орсноор тэдгээрийн микробиологийн ба биохимийн шинж хүн, амьтны экологид сөрөг утгаар идэвхижих, үүнийг бохир усаар дамжин ирж буй бичил биетний эвшил, таатай орчинг тэтгэнэ. Энэ нь өвчний нян тараах | | | х | | |
| 3 | Үйлдвэрийн доторхи ажлын байрны нөхцөл тааламжгүй, химийн бодисын хадгалалт, хамгаалалт мүү байх, агаар дахь бохирдуулагч бодис зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх, хөдөлмөр хамгааллын горим дэглэм зөрчигдөх зэргээс ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө | | | х | | |
| Нийт | | 0 | 0 | 3 | 0 | 0 |
| Хувиар | | 0 | | 100% | 0 | 0 |



| | |
|---------|---|
| Дүгнэлт | Тухайн төсөл хэрэгжих орчмын ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг тогтооход нийт сөрөг нөлөөллийн 100 % нь дунд нөлөөтэй гэсэн ангилалд хамрагдаж байна. Тиймээс гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдлыг дунд гэж дүгнэв. |
|---------|---|

3.8 Төслөөс түүх, соёлын дурсгалт зүйлст нөлөөлөх байдал, үнэлгээ

Тухайн үйлдвэрийн барилга байгууламжийн ойролцоо буюу эдэлбэр газарт түүх дурсгалын зүйлс болон археологи, палеонтологийн олдвортой газар байхгүй. Иймд энэхүү төслийн үйл ажиллагаанаас түүх соёлын дурсгалт зүйлс болон археологи палеонтологийн олдворт ямар нэгэн байдлаар сөрөг нөлөөлөл байхгүй юм.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Зорилго, зорилт: Яармаг ХХК-ны арьс боловсруулах үйлдвэрийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2022 онд “Грийн Солушн” ХХК-ийн боловсруулсан Арьс шир боловсруулах үйлдвэр төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсэн үнэлгээний тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал (төгрөг) | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|--------------------|--|--|---------------------------------|-------------|--|------------|----------------------|------------------------------------|--|
| | 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. | 9. |
| 5.1. Агаарын чанар | | | | | | | | | |
| | Бохир усны шугам хоолойн битүүмжлэл алдагдсанаас нэвчиж байгальд асгаран орчны агаарыг бохирдуулах; | Үйлдвэрийн бохир усны шугам хоолойг тогтмол цэвэрлэх, хатуу болон шингэн хаягдлаар агаар бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авах; | Үйлдвэрийн бохирын шугам хоолой | | Ажил үүргийн хуваарийн дагуу хийгдэнэ. | | | Үйл ажиллагааны турш | Агаарын тухай хууль MNS 4585:2016 Агаарын чанар. Төхнийкийн ерөнхий шаардлага MNS 4990:2015 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ |
| | Арьсны тосыг дутуу авснаас болон хаягдал бохир ус хүчилтөрөгчтэй исэлдсэний улмаас хийн төлөвт шилжсэн хэсэг нь агаарт тархаж үнэр гарах | Арьсны тосыг гүйцэд авах, ургамлын ба цагаан идээлэгтэй технологийг нэвтрүүлэх зэргээр технологи байнга ашиглах | Химийн боловсруулалтын үйлдвэрт | | Хөрөнгө оруулалтын зардлаар хийгдэнэ | | | Үйл ажиллагааны турш | |
| | Арьс шир боловсруулах үйлдвэрт хэрэглэгдэж байгаа химийн бодисын ууршилтаас | Химийн бодис асгарч ууршихаас бүрэн хамгаалах, орц, норм хэмжээг хэтрүүлэхээс сэргийлж байнгын хяналт тавьж ажиллах; | Химийн боловсруулалтын үйлдвэрт | | Үйл ажиллагааны зардал | | | Үйл ажиллагааны турш | |
| | Ажлын байрны температур, гэрэлтүүлэг, чийг, дуу чимээ, шуугиан зэрэг ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага зөрчигдөж агаарын бохирдлын нөлөөлөл үзүүлэх болзошгүй. | Агаар дахь хорт бодисын хэмжээг ЗДХ-нээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын температур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг хянаж, стандартын хэмжээнд байлгах. | Үйлдвэрийн дотор ажлын байранд | ш | 25,0 | 5 | 125,0 | Үйлдвэрлэлийн явцад улиралд 1 удаа | |

| 5.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөц | | | | | | | | |
|--|---|---------------------------------|--|-------|---|-------|-----------------------------------|---|
| Үйлдвэрийн технологийн усны хэрэглээнээс үүдэн цэвэр усны нөөцөд хомсдол үүсэх эрсдэлтэй | Усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх, ус хэмнэлттэй технологийг байнга ашиглах | Химийн боловсруулалтын үйлдвэрт | Ажил үүргийн хуваарийн дагуу хийгдэх тул үйл ажиллагааны зардалд багтана | | | | Үйл ажиллагааны турш | Усны тухай хууль, 2012 MNS 6561:2015 Хүрээлэн буй орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага. MNS 6734:2018 Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5582:2006 Усны чанар. Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрээс урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлэх технологийн хаягдал ус. |
| | Тоолуурын заалтын дагуу цэвэр ус ашигласны болон бохир ус татан зайлуулсны төлбөрийг цаг тухайд нь төлж байх; | Химийн боловсруулалтын үйлдвэр | Тоолуурын заалтын дагуу төлөх. | | | | Үйл ажиллагааны турш | |
| Хаягдал бохир ус стандартад заасан хэмжээнээс давах, улмаар газрын доорх ус бохирдох сөрөг нөлөө үзүүлэх | Хаягдал усны стандартын дагуу урьдчилан цэвэрлэгээг хийж УЦА-нд нийлүүлэх | Үйлдвэрээс гарч буй усанд | Ажил үүргийн хуваарийн дагуу хийгдэх тул үйл ажиллагааны зардалд багтана | | | | Үйл ажиллагааны турш | |
| | Механик хольц шүүх сараалж засвар үйлчилгээ | Бохирын шугамын хэмжээгээр | ш | 200,0 | 1 | 200,0 | Үйл ажиллагааны турш | |
| 5.3. Хөрсөн бүрхэвч | | | | | | | | |
| Үйлдвэрийн болон ахуйн гаралтай хатуу хог хаягдал, шингэн бохир усаар хөрс бохирдох; | Хөрсний бохирдлын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар тогтоосон хугацаанд хийлгэж байх; | Үйлдвэрийн бүсэд | ОХШХ-ийн зардалд тооцох | | | | Үйлдвэрлэлийн явцад жилд 1-2 удаа | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А/82/128 тоот тушаал MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрс |
| | Үйлдвэрийн аюултай хог хаягдлыг “Цэцүүх трейд” ХХК-тай хийсэн гэрээний дагуу зайлуулж байх; | Үйлдвэрийн бүсэд | Хог хаягдлын зардалд тооцсон | | | | Үйлдвэрлэлийн явцад жилд 1-2 удаа | |

| | | | | | | | | | |
|--|---|--|------------------|--------------------------------|------|------|---------|-----------------------|---|
| | Химийн боловсруулах цехийн хойд тал болон механик боловсруулах цехийн зүүн талын шороон зам бүхий газар химийн бодис (хром)-оор бохирдсон | Үйлдвэрийн гадна талбай дахь бохирдсон тохиолдолд хөрсийг саармагжуулах, бохирдлыг бууруулах, цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх; | Үйлдвэрийн бүсэд | Үйл ажиллагааны зардалд тусна. | | | | Үйл ажиллагааны явцад | бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. |
| 5.4. Ургамлан нөмрөг | | | | | | | | | |
| | Түрээсийн байр-Монгол шир ХХК эзэмшлийн талбайд нөхөн тарилт хийх | Үйлдвэрийн гадна орчныг зүлэгжүүлэх, цэцэг тарьж тохижуулах | Төслийн талбайд | ш | 20,0 | 15,0 | 300,0 | 2024 | MNS 5918:2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн ерөнхий шаардлага |
| | | Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих | | | | | 1 500,0 | 2024 онд | |
| Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний нийт зардал | | | | | | | 2 125,0 | | |

6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг, нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал (мян. төг) | Нийт зардал (мян. төг) | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|-------------|---|---|---|---|---------------------------|------------------------|------------------------------|---|
| | 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. |
| 1 | Ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй | Ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хамгаалах хэрэгслээр хангах; Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах | Үйлдвэрийн технологийн дамжлага бүрт ажиллагсдын хүрээнд | Үйл ажиллагааны зардлаар | | | Жил бүр | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 311 дүгээр тогтоолын хавсралт “Галын аюулгүй байдлын тухай” хууль, MNS 4244:1994 Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага |
| | | | | 25 | 75,0 | 1 875,0 | Жилд нэг удаа | |
| 2 | Эрх зүйн зохицуулалтын дутмаг байдал | Дотоод хяналтын журам боловсруулан батлуулж, түүнийг мөрдөж ажиллах | Нийт үйлдвэрийн хүрээнд | Үйлдвэрийн удирдлагын үйл ажиллагаагаар | | | | |
| 3 | Осол дөхөх тохиолдлын болзошгүй нөлөө | Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх | ХАБЭА, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд | Ажил үүргийн хуваариар | | | Тогтмол | |
| 4 | Үйлдвэрийн ослын уршигт байдлын болзошгүй нөлөө | Болзошгүй аваарь ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах, сэлбэх; | | 2 | 100,0 | 200,0 | | |
| 5 | Гал түймрийн болзошгүй эрсдэл | Гал түймрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах, сэлбэх; | | 2 | 100,0 | 200,0 | Тогтмол | |
| Нийт | | | | | | 2 275,0 | | |

7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал (мян.төгрөг) | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|-------------|----------------------|---|-------------------------------|-------------|-------------------------|------------|--------------------------|-------------------------------------|---|
| 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. | 9. | |
| 1 | Ахуйн | Шингэн хог хаягдал | Ажиллагсдын хэмжээнд | м3 | - | - | Ү/а зардалд | Үйл ажиллагаа явагдаж буй хугацаанд | “Ус бохирдуулсаны төлбөрийн тухай” хууль “Хог хаягдлын тухай” хууль Засгийн газрын 2018 оны 05-р сарын 02-ны өдрийн 116-р тогтоолоор баталсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах устгах болон бүртгэх, тайлагнах журам” болон “Аюултай хог хаягдлын жагсаалт” |
| | | Хатуу хаягдлыг түр хадгалж байгаад зайлуулах | Ажиллагсдын хэмжээнд | тн | - | - | Ү/а зардалд | | |
| 2 | Үйлдвэрлэлийн | Шингэн бохир ус зайлуулсны төлбөр төлөх | Үйлдвэрийн хэмжээнд | м3 | - | - | Ү/а зардалд | | |
| | | Хатуу хаягдлыг түр хадгалж байгаад зайлуулах | Үйлдвэрийн хэмжээнд | тн | - | - | Ү/а зардалд | | |
| 3 | Аюултай | Химийн бодисын сав баглаа боодлыг зайлуулах | Хүрээлэн буй орчны бохирдол | тн | 835,0 | - | 835,0 | Жил бүр | |
| Нийт | | | | | | | 835,0 | | |

8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал (мян. төгрөг) | Нийт зардал (мян. төгрөг) | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|----|---|---|--------------------|----------------|------------------------------|---------------------------|---------|---|
| 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. | |
| 1 | АГААРЫН ЧАНАР | | | | | | | |
| | Бохирдлын цэгэн эх үүсвэр: - Нүүрстөрөгч - Хүхэрт устөрөгч - Азотын давхар исэл - Хүхэрлэг хий /SO ₂ / - Нийт тоосны агууламж /TSP/ | - Химийн боловсруулалтын цех - Механик боловсруулалтын цех | Жилд 2 удаа | 2 | 36,0 | 72,0 | | - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS 5002:2000 |
| | Гадаад орчны дуу шуугиан Ажлын байрны дуу шуугиан | - Дуу шуугиан ихтэй ажлын байруудад | Жилд 2 удаа | 2 | 36,0 | 72,0 | | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. |

| | | | | | | | | |
|---|--|-------------------------------------|--|---|-------|-------|--|--|
| | | | | | | | | Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 Дуу чимээхэвийн норм, түвшний хэмжээ |
| 2 | ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УСНЫ ЧАНАР | | | | | | | |
| | Гадаргын болон газар доорх усны чанар:pH, усны түвшин, TDS (нийт ууссан давс), нийт хатуулаг (CaCO3), ууссан хүчилтөрөгч, умбуур, БХХ, ХХХ | - Хромын шугам - Сульфидын шугам | Үйлдвэрлэлийн явцад улиралд 1 удаа | 4 | 66,77 | 267,0 | Шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор хийлгэнэ. | MNS 5582:2006 Арьс шир, үслэг боловс- руулах үйлдвэрээс урьдчилан цэвэрлэх байгууламжид ний- лүүлэх технологийн хаягдал ус |
| 3 | ХӨРСӨН БҮРХЭВЧ | | | | | | | |
| | Хөрсөн дэх хүнд металлуудын агууламжийг тодорхойлох | | Жилд 2 удаа (хавар) | 2 | 36,0 | 72,0 | Шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор хийлгэнэ | MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| | Нийт | | | | | 484,0 | | |

9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|--|----------------------------|------------------------|-----|-----|---------------------------------|---------|
| | | | 2024 он | | | | |
| | | | Сар | Сар | Сар | | |
| | 1. | 2. | 3 | 4 | 5 | 6. | 7. |
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах | Ү/А зардалд | | | | Яармаг ХХК | |
| 2 | Байгаль орчныг хамгаалах, осол аваар , гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1жилд 2удаа сургалт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах | 1 000,0 | | | | Яармаг ХХК | |
| 3 | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-т хүргэн өгч байх | Ү/А зардалд | | | | Яармаг ХХК | |
| 4 | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө | Ү/А зардалд | 5 сар | | | Яармаг ХХК | |

| | | | | | | | |
|-------------|---|------------------------------------|-------|-------|--|------------|--|
| 5 | Бүх ажиллагсдыг жилд 1 удаа нарийн мэргэжлийн эмч нарт хамруулж байх | Осол эрсдэлийн төлөвлөгөөнд тусгав | 6 сар | 7 сар | | Яармаг ХХК | |
| 6 | Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах , галын аюулгүй ажиллагааны самбар шинэчлэх | 100,0 | | | | Яармаг ХХК | |
| 7 | ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах | 500,0 | | | | Яармаг ХХК | |
| 8 | Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах | Ү/А зардалд | | | | Яармаг ХХК | |
| 9 | Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал | Осол эрсдэлийн төлөвлөгөөнд тусгав | | | | Яармаг ХХК | |
| Нийт | | 1 600,0 | | | | | |

10. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал (төгрөг) | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар |
|---|--|--|---|--|---------------------------|--|------------------------|
| | 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. |
| 1 | Төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин аялал жуулчлалын яам/ | БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай | Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор | Үйл ажиллагааны зардалд | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг баталгаажуулах | БОАЖЯ |
| 2 | Хан-Уул дүүргийн ЗДТГ-т | БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай | Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор | Үйл ажиллагааны зардалд | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд таниулж санал авах | Төсөл хэрэгжих дүүрэгт |